

**ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн жилийн үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс
гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76.1.11 дэх заалт, “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн дүрмийн 7.8.3 дахь заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:


1. “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

2. Тус компанийн 2019 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэхийн зэрэгцээ Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд гарсан санал, өгөгдсөн үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЕРӨӨГЭРЭЛ



“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2020 оны
04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа
эзэмшигчдийн ээлжит хурлын 01 тоот
/ГЭРЭЭНИЙ/ ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ДҮГНЭЛТ

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2019 оны зорилтуудын хэрэгжилтийн талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Компанийн 2019 оны газар тариалангийн үйл ажиллагаанд тавьсан зорилго нь тариалалтыг технологийн дагуу сайн гүйцэтгэх, 1 га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалан үржил шимийг хадгалах, тариалах талбайд хэмжээг нэмэгдүүлж ажиллах байв. Гүйцэтгэх удирдлага тавьсан зорилгоо хангахад чиглэсэн олон арга хэмжээнүүдийг авч ажилласан байна. Өнгөрсөн онд 4353 га талбайд улаан буудай, 303 га-д тосны ургамал, арвай, овьёос, вандуй, гурвалжин будаа тариалж, ургац олон жилийн дундажын орчимд байжээ. Нийт 6.1 мян тн буудай (га-аас 14 цн), 25.3 тн овьёос, вандуй, 12.7 тонн халтар арвай, 1.9 тн гурвалжин будаа, 104 тн тосны ургамал хураан авсан байна. Мөн 2518 га газарт уринш хийж, 1200 гаруй га талбайг хямд өртгөөр хашаажуулж эхэлсэн байна.

Гурилын үйлдвэрийн хувьд үйлдвэрлэл, борлуулалтыг 50 гаруй хувиар нэмэгдүүлэх, үйлдвэрийн байрыг өргөтгөж, ажиллагсдын ажиллах нөхцлийг сайжруулах, тоног төхөөрөмжид урсгал засвар хийж, бэлэн бүтээгдэхүүний болон түүхий эдийн агуулахуудын багтаамжийг нэмэгдүүлэх зэрэг томоохон зорилтуудыг тавьж ажиллажээ. Гэвч эх үүсвэрийн дутагдлаас үүдэн зарим зорилтуудын хэрэгжилт хангалтгүй байв. Гурилын үйлдвэр өнгөрсөн онд нийт 7.8 мян тонн буудай тээрэмдэж, 6.3 мян тн гурил, 1.5 мян тн дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн байна. Үтрэмд 2019 оны ургацаас 8.4 мян тн буудай хүлээн авсан байна. Харин ХАБЭА, чанарын удирдлагын чиглэлээр цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 2018 онд нэвтрүүлсэн “Чанарын удирдлагын тогтолцоо”-ны явцын магадлах аудитад амжилттай хамрагдсан байна.

2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг 2018 онд батлуулсан дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан байна. Компанийн газар тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөгөө үндсэндээ биелж, гурилын үйлдвэрлэлийн төлөвлөгөө тасарснаар компанийн санхүүгийн төлөвлөгөө 80-90%-тай биелсэн байна. Компанийн нийт орлого өмнөх оноос 8.2% өсч, хүүгийн зардал буурснаар цэвэр ашиг өмнөх оноос 3 дахин нэмэгджээ.

2019 онд ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу хүсэлт ирүүлсэн нийт 109 хувьцаа эзэмшигчийн 1.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг олгоод байна. Компанийн хувьцааны арилжаа харьцангуй идэвхтэй буюу 179 өдөр явагдаж, 2-р самбарт үргэлжлэн байршиж, ТОП20 индексийг бүрдүүлэгч хувьцаа хэвээр байна.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн гүйцэтгэх удирдлага 2019 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлээгүй боловч зардлаа хэмнэж чадсанаар ашигт ажиллагааг нэмэгдүүлсэн тул хангалттай ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

Компанийн санхүүгийн тайлангуудыг компанийн вэб хуудас (www.altanduulga.mn) болон Монголын Хөрөнгийн Биржийн вэб хуудсаар холбогдох хуулийн хугацааны дотор олон нийтэд мэдээлсэн тул хувьцаа эзэмшигчид тайлангуудтай танилцах боломжоор хангагдсан гэж үзэж байна.

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн дүрмийн 7.8.1, Тооллогын комиссын тогтоолыг тус, тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

НЭГ. ”Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр дараах хүмүүсийг сонгосугай. Үүнд:

А.Ердийн гишүүнээр:


1. Доржпүрэв овогтой Батхуяг
2. Заяат овогтой Батсүх
3. Доржпүрэв овогтой Дуламсүрэн
4. Мандшир овогтой Зулзаяа
5. Цэдэв овогтой Наран-Учрал
6. Очирхүрээ овогтой Тунгалаг

Б.Хараат бус гишүүнээр:

1. Лхам овогтой Даваа
2. Төмөр овогтой Мөнхгэрэл
3. Даваажав овогтой Энхтогтох

ХОЁР. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм, дотоод журмуудад заасан үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЕРӨӨГЭРЭЛ

**ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

№03

Улаанбаатар хот


**ТУЗ-ийн гишүүдийн цалин
урамшууллын тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат Компанийн дүрмийн 7.8.7, 7.44-д заасныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2020 оны цалин, урамшуулал, нэмэгдэл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцооны нэмэгдлийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай” 04 дүгээр тогтоолын дагуу олгож байхаар тогтсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тогтмол цалин, урамшуулал, нэмэгдлийг жилийн эцэст, оролцооны нэмэгдлийг тухай бүр олгож байхыг нягтлан бодогч Н.Одончимэгт зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЕРӨӨГЭРЭЛ